


|  |  |  |                 |
|--|--|--|-----------------|
|   | (ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж) | Захирлын 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн <i>А.А.</i> тоот тушаалын долдугаар хавсралт |                 |
| Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал<br><br><i>(Ч.Эрдэнэтуяа)</i> |  | Баталсан огноо: 2026.01.14   | Хуудасны тоо: 4 |
| Баримт бичгийг хариуцагч: Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан   |  | Танилцах албан тушаалтнууд: Нийт багш, ажилчид   |                 |

**БАГШ, АЖИЛТНУУДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,  
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР**

**Эх хувь**

Баримтжуулсан мэдээллийн дугаар:  
Хувилбарын дугаар: V1.2026

**Түгээлт**

Энэхүү хөтөлбөр нь манай сургуулийн өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ хөтөлбөр батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

**Зөвшөөрөл**

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү хөтөлбөрийг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

|               | Албан тушаал  | Овог нэр               | Огноо      |                         |
|---------------|---|------------------------|------------|-------------------------|
| Боловсруулсан | Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан   | Батбуян Буянжаргал     | 2026.01.07 | <i>Б.Мухуй</i>          |
| Хянасан       | ДЧБСХААжилтан   | Энх-Амгалан Шинэжаргал | 2026.01.13 | <i>Энх-Амгалан</i>      |
| Зөвшөөрсөн    | ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал | Чимэд Эрдэнэтуяа       | 2026.01.14 | <i>Чимэд Эрдэнэтуяа</i> |

## НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Хөтөлбөрийн өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт хөтөлбөрт орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

| Өөрчлөлт оруулсан бүлэг | Өөрчлөлтийн товч утга | Хувилбарын дугаар | Сүүлд шинэчлэгдсэн огноо | Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр | Баталсан албан тушаалтан, овог, нэр |
|-------------------------|-----------------------|-------------------|--------------------------|--|-------------------------------------|
|                         |                       |                   |                          |  |                                     |
|                         |                       |                   |                          |  |                                     |

## АГУУЛГА

|  |     |
|--|-----|
| <b>НЭГ.</b> Нийтлэг үндэслэл.....          | 1   |
| <b>ХОЁР.</b> Хөтөлбөрийн зорилго.....      | 2   |
| <b>ГУРАВ.</b> Хөтөлбөрийн зорилт.....      | 1-3 |
| <b>ДӨРӨВ.</b> Хүрэх үр дүн.....            | 4   |
| <b>ТАВ.</b> Хөтөлбөрийн хугацаа.....       | 4   |
| <b>ЗУРГАА.</b> Хөтөлбөрийн санхүүжилт..... | 4   |



№ Х-4-003

**Багш, ажилтнуудын ажиллах, нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр**  
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-14

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

## Нэг.Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуулийн 61.1.2 дахь Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, тэдгээрийн талаар төрийн байгууллагуудаас хэрэгжүүлэх бодлогыг уялдуулан зохицуулахаар заасан.

2. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь сургуулийн захиргаа, үйлдвэрчний хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”, сургуулийн жил бүрийн “Хөдөлмөрийн дотоод журам”, “Сургуулийн дүрэм”, “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд нарийн тусгагдсан байна.

3. Уг хөтөлбөр зөвхөн “Политехник коллеж”-ийн хүрээнд хэрэгжинэ.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Сургуулийн багш, ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, амралт сувилалын үйлчилгээнд хамруулах, эрүүл мэндийг нь хамгаалахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оршино.

### Гурав.Хөтөлбөрийн зорилт

Зорилт 3.1.Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгох. Үүнд:

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан, ажилтнуудын цалинг тухай бүрт шинэчлэн тогтоож мөрдөх;
- төрийн албан хаагчдад олгох нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг Засгийн газрын тогтоол шийдвэрийг баримтлан тогтоож олгоно;
- төрийн албаны болон Боловсролын хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын Ерөнхий хуулинд заасан хөнгөлөлтүүдийг үзүүлэх арга хэмжээ авах;
- гачигдалтай болон тэмдэглэлт үйл явдал, арга хэмжээний үед олгох буцалтгүй мөнгөн тусламжийн хэмжээг жил бүр шинэчлэн тогтоон олгож байх;
- багш ажилтнуудын ажлын үнэлгээг харгалзан ур чадварын нэмэгдэл олгох (төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан журмын дагуу);
- багш, ажилтнуудад үр дүнгийн урамшуулал олгох;
- орон нутгийн нэмэгдэл, нутгийн дэмийн нэмэгдэл



№ Х-4-003

**Багш, ажилтнуудын ажиллах, нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр**  
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-14

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

- ганц бие, өрх толгойлсон болон шинэ гэр бүл болсон, шинэ хүүхэдтэй залуу гэр бүлд эд хөрөнгийн болон санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлэх;
- хамт олноо төлөөлөн аливаа уралдаан, тэмцээнд оролцож буй багш ажилтнуудад амжилт гаргасан тохиолдолд амжилтыг нь урамшуулах;

Зорилт 3.2. Албан тушаалийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл боломжоор хангах. Үүнд:

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.2.1. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, ширээ, сандал, компьютер, принтер, скайнер, хувилагч болон бусад техник хэрэгслэлээр хангах;

3.2.2. албан үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үед унаагаар хангах;

3.2.3. ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах. (халаалт, гэрэлтүүлэг, өрөөний тохижилт, цахилгаан хангамжийн үйлчилгээ, г.м);

3.2.4. үйлчилгээний ажилтнуудыг ажлын тусгай хувцас, хамгаалах болон үйлчилгээнд шаардагдах хэрэгсэл, материалаар тасралтгүй хангах;

Зорилт 3.3. Орон сууцны нөхцөлөө сайжруулахад, орон байраар хангагдахад нь хөрөнгө санхүүгийн болон зохих туслалцаа, дэмжлэг үзүүлэх. Үүнд:

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.3.1. багш ажилтнуудыг амьдрах орчин нөхцөлөө сайжруулах, шинээр орон сууц худалдан авахад төсөл хөтөлбөрт хамруулах;

3.3.2. багш ажилтнуудын орон байрны нөхцөлөө сайжруулах зорилгоор банкнаас зээл авахад нь зохих дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

3.3.3. багш ажилтнууд эдэлбэр газартай болоход туслах;

Зорилт 3.4. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх. Үүнд:

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.4.1. багш ажилтнуудад эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгох;

3.4.2. багш ажилтнуудыг жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж, шаардлагатай хүмүүст эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэх, амралт сувилалд явахад нь дэмжлэг үзүүлэх;



№ Х-4-003

Багш, ажилтнуудын ажиллах, нөхцөл,  
нийгмийн баталгааг хангах хөтөлбөр  
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн  
санд

Баталсан огноо: 2026-01-14

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

3.4.3.багш, ажилтнуудыг жилд 1 удаа эрүүл мэндийн 5 сорилд хамруулж, чийрэгжүүлэх, бялдаржуулах арга хэмжээ авах;

3.4.4.ажилтнуудад зориулсан чийрэгжүүлэх танхимд тогтмол хичээллэхэд таатай нөхцөл, боломжоор хангаж ажиллах;

Зорилт 3.5. Албан хаагч өөрөө өвдөж эмчлүүлж, сувилуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлэх. Үүнд:

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.5.1.ээлжийн амралтаараа өөрийн болон эхнэр, нөхрийн төрсөн нутаг амрах, рашаан сувилалд явж байгаа ажилтнуудад унааны зардлыг нийтийн тээврийн үнэ тарифаар тооцон 2 жилд нэг удаа олгох;

3.5.2.тухайн албан хаагчийн сарын цалингаас илүү төлбөртэй эмчилгээг зайлшгүй хийлгэх болсон тохиолдолд эмнэлгийн тодорхойлолт, эмч нарын зөвлөгөөний шийдвэрийг харгалзан тухайн ажилтны эмчилгээний зардалд нь тодорхой мөнгөн тусламж олгож, дэмжлэг үзүүлэх;

Зорилт 3.6. Амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах. Үүнд:

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.6.1.эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж жилд хоёроос доошгүй удаа идэвхитэй амралт зохион байгуулах;

3.6.2.баяр, тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан багш, ажилчдын дунд үдэшлэг, уулзалтыг улирал тутам зохион байгуулах;

3.6.3.сургуулийн аварга шалгаруулах спортын уралдаан тэмцээнийг жилд нэг удаа зохион байгуулах;

3.6.4.багш, ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор долоо хоног бүрийн тодорхой гарагт спорт зааланд чөлөөт тоглолт явуулах;

3.6.5.сургуулийн бялдаржуулах танхимыг байгуулж, тогтмол ашиглах;



№ X-4-003

**Багш, ажилтнуудын ажиллах, нөхцөл,  
нийгмийн баталгааг хангах хөтөлбөр**  
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн  
санд

Баталсан огноо: 2026-01-14

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

3.4.3.багш, ажилтнуудыг жилд 1 удаа эрүүл мэндийн 5 сорилд хамруулж, чийрэгжүүлэх, бялдаржуулах арга хэмжээ авах;

3.4.4.ажилтнуудад зориулсан чийрэгжүүлэх танхимд тогтмол хичээллэхэд таатай нөхцөл, боломжоор хангаж ажиллах;

Зорилт 3.5. Албан хаагч өөрөө өвдөж эмчлүүлж, сувилуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлэх. Үүнд:

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.5.1.ээлжийн амралтаараа өөрийн болон эхнэр, нөхрийн төрсөн нутагт амрах, рашаан сувилалд явж байгаа ажилтнуудад унааны зардлыг нийтийн тээврийн үнэ тарифаар тооцон 2 жилд нэг удаа олгох;

3.5.2.тухайн албан хаагчийн сарын цалингаас илүү төлбөртэй эмчилгээг зайлшгүй хийлгэх болсон тохиолдолд эмнэлгийн тодорхойлолт, эмч нарын зөвлөгөөний шийдвэрийг харгалзан тухайн ажилтны эмчилгээний зардалд нь тодорхой мөнгөн тусламж олгож, дэмжлэг үзүүлэх;

Зорилт 3.6. Амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах. Үүнд:

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.6.1.эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж жилд хоёроос доошгүй удаа идэвхитэй амралт зохион байгуулах;

3.6.2.баяр, тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан багш, ажилчдын дунд үдэшлэг, уулзалтыг тухай бүр зохион байгуулах;

3.6.3.сургуулийн аварга шалгаруулах спортын уралдаан тэмцээнийг жилд нэг удаа зохион байгуулах;

3.6.4.багш, ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор долоо хоног бүрийн тодорхой гарагт спорт зааланд чөлөөт тоглолт явуулах;

3.6.5.сургуулийн бялдаржуулах танхимыг байгуулж, тогтмол ашиглах;



№ X-4-003  
Багш, ажилтнуудын ажиллах, нөхцөл,  
нийгмийн баталгааг хангах хөтөлбөр  
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн  
санд

Баталсан огноо: 2026-01-14  
Хувилбар: V1.2026  
Нууцын зэрэг: Нээлттэй

## Дөрөв.Хүрэх үр дүн

4.1.Багш, ажилтнууд ажиллах нөхцөл, бололцоогоор бүрэн хангагдаж, ажлаа тав тухтай хийх орчин сайжирана.

4.2.Багш, ажилтнуудад шаардагдах техник хэрэгслэлээр бүрэн хангагдаж, тухайн үеийн тавигдаж байгаа шаардлагад нийцүүлэн ажлаа явуулах бололцоотой болно.

4.3.Төрийн албан хаагчдын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх төлбөр тухайн үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу бүрэн тогтоогдож олгогддог асуудал хэвшил болно.

4.4.Багш, ажилтнууд үр дүнтэй ажиллаж, амжилт, үр бүтээл гаргасан тохиолдолд хууль тогтоомжийн дагуу төрөөс шагнал, урамшил хүртэх явдал шуурхай болно.

4.5.Багш, ажилтнуудын амьдрах орчин нөхцөл зохих хэмжээгээр дээшилнэ.

4.6.Багш, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах асуудал сайжирч, тэдний өвчлөл буурч, боловсролын үйлчилгээний үр дүн сайжирана.

4.7.Багш, ажилтнуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх асуудал дээшилнэ.

## Тав.Хөтөлбөрийн хугацаа

Хөтөлбөрийг 2025-2028 онд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ.

## Зургаа.Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

1. сургуулийн жил бүрийн төсөвт тусгагдсан батлагдсан хөрөнгө;
2. сургуулийн үйлдвэрчний эвлэлийн хөрөнгө;
3. хамт олны хандив, тусламж;